

АЙМГИЙН ХЭМЖЭЭНИЙ БИЕИЙН ТАМИР СПОРТЫН

ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

/ шинэчилсэн найруулга/

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол улсын биеийн тамир спортын тухай хууль, Монгол улсын их хурлын 05 тоот тогтоол, Монгол улсад Биеийн тамир спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, Сэлэнгэ аймгийн ИТХурлаар баталсан “Спортлог- Сэлэнгэчүүд” хөтөлбөр, МУЗГазрын 05 тоот тогтоолуудын хэрэгжилт ардын уламжлалт тоглоом наадгай үндэсний болон багийн спорт, мэргэжлийн спортод бие бялдрыг чийрэгжүүлэх, орчин үеийн биеийн тамир спортын арга хэмжээг зохион байгуулан зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Хоёр. Биеийн тамир спортын арга хэмжээ

2.1. Байгууллага дээр зохиогдож буй үйл ажиллагааг Засгийн газрын 183 дугаар тогтоол, Эрүүл мэндийн сайд, Санхүү эдийн засгийн сайдын / цаашид ЭМС, СЭЗСайд гэх / хамтарсан 53/45 тоот тушаал, дагуу зорилго чиглэл тодорхой агуулга нь оролцогчдын нас сэтгэхүйн онцлогт тохирсон байх.

2.2. Биеийн тамир спортын үйл ажиллагаа нь оролцогчдын эрхийг хүндэтгэсэн төрөл хэлбэр нь тодорхой зохих журмын дагуу төлөвлөгөөг гарган 15- 1 сарын өмнө мэдэгдсэн байх.

2.3. Уралдаан тэмцээний үйл ажиллагааны удирдамж заавар журам шалгуур нь үнэн зөв бодитой, үнэлгээ өгөх боломжтой ил тод, олон улс болон монгол улсад мөрдөгдөж буй заавар дүрэм журмыг үндэслэл болгох.

2.4. Аймгийн аварга шалгаруулах өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн тэмцээнд /баг хувь төрөл/ нутгийн харьяалалгүй тамирчинг нуун дарагдуулсан бичиг баримтгүй оролцуулсан тохиолдолд тухайн төрлөөс хасах /тоглохоос өмнө, хэрэв тоглолт явагдсан бол тухайн тамирчины амжилтыг / 2 дахь удаагаа давтагдвал тухайн багш дасгалжуулагч удирдаж яваа хүнийг 1 жилийн хугацаагаар ямарч тэмцээн уралдаанд оролцуулах эрхийг хасч зөрчлийн хуулийн дагуу арга хэмжээ тооцох

2.5. Аймгийн аварга, нэрэмжит тэмцээнийг ялгаатай болгон зааглаж аймгийн аварга шалгаруулах тэмцээнд орон нутгийн харьяат иргэдийг оролцуулан Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхийг өгч шагналын жишгийг Монгол улсын Засгийн газрын 173 дугаар тогтоолын 2-р хавсралтыг баримтлан түүний 10-

50 хувь хүртэл олгоно. Нэрэмжит тэмцээнд орон нутгийн харьяалал харгалзахгүй тухайн гаргасан заавар журмаар.

2.6. Аймгийн аварга шалгаруулах спорт тоглоом багийн спортын төрлүүдийн тэмцээнд бүх сумын / тосгодыг тухайн сумаар нь тооцно/ 50 % бүрдвэл, ганцаарчилсан тэмцээнд бүх сумын 70 % оролцсон тохиолдолд Аймгийн аварга шалгаруулах тэмцээн гэж тооцох бөгөөд үүнээс бага тамирчин оролцвол төрөл жишиг нэршлийг тухайн спортын төрлийн техникийн зөвлөгөөн дээр төрөл зай, тоглох үйл ажиллагааг шийдвэрлэнэ

2.7. Аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит тэмцээнд оролцож байгаа / баг хувь төрөл/ бүх тамирчид дасгалжуулагчид удирдаж яваа хүмүүс тэмцээнээ хүндэтгэн оролцох бөгөөд зохион байгуулагчид шүүгчидтэй маргаан гаргах, согтууруулах ундааны зүйл хэрэглэн маргалдах тохиолдолд тухайн тэмцээний сонгогдсон ерөнхий шүүгчтэй тухайн багийн ахлагч, дасгалжуулагч харилцаа үүсгэн маргааныг шийдвэрлэх.

2.8. Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцож байгаа / баг хувь төрөл/ бүх тамирчид дасгалжуулагчид уг төрлийнхөө тэмцээнийг хүндэтгэн оролцох бөгөөд зохион байгуулагчид шүүгчидтэй дүрмийн бус маргаан гаргах, согтууруулах ундааны зүйл хэрэглэн маргалдах тохиолдолд Биеийн тамир спортын тухай хуулийн 28.1, 28,2 дахь заалт, Зөрчлийн тухай хуулийн 6,19 дахь заалтуудыг үндэслэн эрүүгийн болон зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэх.

2.9. Спортын үйл ажиллагаа явуулах объектыг тухайн төрлийн онцлогт тохируулан чимэглэж, бэлтгэл ажлын төлөвлөгөөг гарган зохион байгуулж хэрэгжүүлнэ

2.10. Төлөвлөгөөнд тусгагдаагүй урлагын тоглолт бусад арга хэмжээг хамтран зохион байгуулахад өөрийн байр талбайг ашиглуулан хэрэглүүлэх тохиолдолд өөрийн орлогийг бүрдүүлэх чиглэлээр дотоод журманд заасан жишгээр олсон орлогын 15-25 хувиар тооцож төлбөр нэхэмжлэх.

2.11. БСШУССайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан а/178, а/144 тоот тушаалаар батлагдсан Магадлан итгэмжлэлээр орж гэрчилгээгээ авч баталгаажсан клуб холбоо, фитнес төвүүдэд спортын болон биеийн тамирын арга хэмжээг явуулах бүрэн эрхийг олгох бөгөөд магадлан итгэмжлэгдсэн журмын дагуу ажиллаж, санхүүжилтээр хангагдан хамтран ажиллах бүрэн боломж нээгдэнэ.

2.12. Усан спортоор сонирхогч, хичээллэгчид болон уралдаан тэмцээнд оролцогчид эрүүл мэндийн үзлэг оношлогоо /цагаан хорхой, мазек, арьс өнгө/ шинжилгээнд хамрагдсан байх ба зайлшгүй усны эрүүл ахуй, гэнэтийн өвчин эмгэгийг байгууллага хариуцах тул зүйлшгүй цагаан хорхойн шинжилгээг усан спортын төвийн лабароторид өгөх.

2,13. Усан спортоор сонирхогч, хичээллэгчид болон уралдаан тэмцээнд оролцогчид цахим мэдээллээр бүртгэгдэн карт олгогдох

2.14. Хувь хүн болон албан байгууллагууд ажилтан ажилчдынхаа төлөө санаачлага гарган усан спортын аку фитнесийн үйл ажиллагаанд тогтмол биеэ чийрэгжүүлэн цаг алдалгүй хамрагдан хичээллэн байгаа иргэдэд урамшуулал олгож болно

2,15.Аймгийн аварга шалгаруулах тэмцээнд тусгайлан бие даасан клуб холбоодын тамирчид оролцож Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрхийг авсан тохиолдолд Аймгийн нэрийг төлөөлөн тодорхой хэмжээний санхүүжилт авч оролцох эрхээр хангагдах ба хэрэв клубынхээ нэрээр оролцсон үед БТСТХуулийн дагуу санхүүжилт болон бусад шагнал урамшууллаас татгалзах болно.

2,16. Тамирчид дасгалжуулагч багш нар бэлтгэл сургуулалт уралдаан тэмцээний үед допингийн шинж агуулсан эмийн бодос /эм/ хэрэглэхийг хатуу хориглох ба хэрэглэсэн шинж тэмдэг илэрвэл БТСТХуулийн дагуу эрүүгийн болон зөрчлийн хуулиар хариуцлага тооцно

Гурав.Эрхийн хураамжийн жишиг

3,1. Аймагт зохион байгуулагдаж байгаа арга хэмжээний төлбөр хураамжийг явуулж буй үйл ажиллагааны зорилго хамрагдах хүрээнээс хамаарч Монгол улсын Засгийн газрын 173 дугаар тогтоолын 2-р хавсралтыг баримтлан түүний 10- 50 хувь хүртэл, БТСГазрын дотоод журам, СЭЗСайд, ЭМСайдын 53/45 тоот тушаалд заасан заалтуудыг үндэслэн жишиг тогтоон мөрдөнө. ХБИргэдийн үйл ажиллагаа хөдөлмөр эрхлэлт үйл ажиллагаанаас шалтгаалан 50 хувийн хөнгөлөлтөөр тооцно.

3,2. Тэмцээний эрхийн төлбөрийн жишиг үнэ / 1 цаг тухайн орон нутаг мян төгрөгөөр /

№	Арга хэмжээний төрөл	Багууд	Сумд	Аймаг-н бүс	Тухайн аймгийн нутг-н Бүс	Тухайн орон нутагт Улс
1	Ангилал бүрт тэмцээн уралдаан Хувь төрөл Багийн	5,000-10000	5,000-10000	5000-30000	5000-20000	5000-30000

	/Орон нутаг/	5000- 20000	10000- 30000	50000- 100000	50,000-80000	30,000-100000
--	--------------	-------------	--------------	---------------	--------------	---------------

3,3.Аймагт орон нутагт зохиогдож буй тасалбарын жишиг

Арга хэмжээний төрөл хэлбэр	Аймгийн аварга	Бүсийн аварга	Улсын аварга
ЕБСургуулийн насны хүүхэд	2000-2500	2500- 5000	5000-10000
Насанд хүрэгчид	2500-5000	5000-8000	5000-10000
Ахмад	2500	3000- 5000	5000

3,4. Ордон, заал, талбай, усан бассейныг иргэд байгууллагуудад түрээсээр болон цагаар үйлчлэхэд дараах журмыг баримтлан ажиллана. Монгол улсын тогтоол шийдвэрээр мөнгөний имфляцид өөрчлөлт орвол хамт олны зөвлөлийн хурлаар дахин жишгийг тогтооно.

Үйлчилгээний хэлбэр	Үнийн тариф		
	Өдөр		
	Төвд	Суманд	Усан бассейн
Хүүхэд том хүн өдөрт /нэг цагаар хүний тоо хамаарахгүй /	40000	25000	6000 / хувь хүнээр /
Усанд бассейнд / нэг цагаар нэг хүн/			12000 / хувь хүнээр /
Бялдаржуулах танхим / нэг хүнээр /	5000	5000	
Теннис / 2 хүнээр/	5000	4000	
Усанд бассейнд нэг сарын үйлчилгээ / 12 удаагийн оролт	-		Хүүхэд 40000 төг том хүн 70000 төг
Усан спортын төвийн саун / нас харгалзахгүй ажлын цагаар /	-		30000 төгрөг
Шинжилгээний дэвтэр	-		5000 төгрөг
Усны карт			3000 төгрөг

Буудлын үнэ / өдөрт нэг хүн /	20000-25000	20000-25000	
-------------------------------	-------------	-------------	--

3.5. Спортын хэрэглэл материалыг иргэд байгууллагуудад нэг өдрөөр хэрэглүүлэх тариф

Хэрэглэл материал	Хэмжих нэгж	Үнэ
Бөмбөг	Ш	10000 төгрөг
Волейболын тор	Ш	15000 төгрөг
Зодог шуудаг	Хос	5000 төгрөг
Засуулын дээл малгай	ком	5000 төгрөг
Ширээний теннисний ширээ	Ком	30000 төгрөг
Тоглолтын хувцас	Хос	25000 төгрөг
Олс	ш	20000 төгрөг
Волейболын шал	ком	100000 төгрөг

3.6. Спортын хэрэглэл материалыг хүлээн авч түрээсээр хэрэглэж байгаа байгууллага тухайн авсан өдрүүдэд эд аж ахуйд хайр гамтай хандан хэрэглэж хугацаанд буцааж өгөх ба хэрэв хэрэглэл материал эвдэрсэн, хагарсан, үрэгдүүлсэн тохиолдолд тухайн хэрэглэлийг зах зээлийн үнээр төлүүлж хохиролыг барагдуулна.

3.7. Энэхүү журам нь харьяа байгууллагуудын дотоод үйл ажиллагаа, арга хэмжээ бүрт журмыг баримтлан ажиллах болно.

3.8. Тухайн орон нутгийн хэмжээнд зохицуулах журманд заагдаагүй төрөл, спортын хэрэглэл материал, бусад арга хэмжээнүүдийг тусгахаар бол байгууллагын удирдлагатай зөвшилцөн заалтуудыг нэмж оруулж болно.

3.9. Улсын аварга болон Биеийн тамир спортын тухай хуулийн 10,2 дахь заалтын дагуу үндэсний хэмжээний наадамд хүүхэд залуучууд, ахмадын/ ХБИргэд адил хамаарна/ уралдаан тэмцээнд оролцуулахдаа төсвийн тухай хууль болон Засгийн газрын 183 дугаар тогтоолын дагуу тухайн арга хэмжээнд оролцуулах шийдвэр гарган төсвийг бүрдүүлнэ.

3, 10. Улс орон даяар зарлагдсан тахал, халдвар өвчлөлийн хэмжээ болон голомт буурахгүй байгаа үед онцгой байдлын комиссоос гаргасан шийдвэр, эрүүл

мэндийн газраас гаргасан зөвлөмжүүдийг дагаж уралдаан тэмцээн, сургалт дасгалжуулалтыг зохион байгуулах.

Тусгай шаардлага

- Түрээлэгч цагийн үйлчилгээг авахын өмнө байгууллагаас тавьсан шаардлага, төлбөр тооцоог бүрэн хийсэн байна.
- Түрээсэлж авч байгаа иргэд, албан байгууллагын ажилчид тухайн ажилтаны тавьсан шаардлагыг бүрэн биелүүлэх бөгөөд үл тоосон тохиолдолд цагийн үйлчилгээг цуцлах хүртэл арга хэмжээ авах болно.
- Халдварт өвчлөлийн үед эсрэг тун вакцинд хамрагдсан гэрчилгээтэй байх
- Халдвараар өвчилсөн бол тусаад эдгэрсэн баталгааны хуудас, баримтжуулах хуудастай байх
- Ямар нэг уралдаан тэмцээн явуулах үед зайлшгүй халдвар хамгааллын дэглэм, дүрэм журмын дагуу төлөвлөсөн байх